



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/365

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Сургуулийн барилгын засвар (Баяннуур сум)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Барс оргил” ХХК-тай 309,288,902 (гурван зуун есөн сая хоёр зуун наян найман мянга есөн зуун хоёр) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т, тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Барс оргил” ХХК-ийн захирал (Б.Мөнхбаяр)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.


5.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 19-ны/ний өдрийн
А/365 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	5,113,542	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	5,113,542	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2,556,771	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	14,800,000	Ү.Бямбасүрэн
5	Нормчлолын сан	460,219	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд
9	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 19-ны/ний өдрийн
А/365 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	Б.Мөнхбаяр	Ү.Бямбасүрэн
2	Цахилгааны инженер	Д.Нэмэхбаяр	
3	ХАБЭА-н ажилтан	Д.Эрдэнэбулган	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Ачааны автомашин	8034 БУЛ	

--о00о--